

Хаяг: JS Tower 10-р давхар - 1002 тоот - Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нарны зам
Улаанбаатар хот, Монгол улс

Утас: (976) 7013 1770
Факс: (976) 7014 1770

Огноо: 2023.02.28.

№ 23/08.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА" ХК-ИЙН УДИРДЛАГАД

Зөрчилгүй санал дүгнэлт

Бид "Хөвсгөл алтандуулга" ХК (Компани гэх) 2022 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2022 оны 12 сарын 31 ний өдрөөр санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан санхүүгийн тайлангууд болон 9-29 хүртэлх хуудсан дахь тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЭЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЭЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд томоохон хэмжээний аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа, тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулах, компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлэмж ашиглаж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурийг баримталдаг. Түүнчлэн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшоох явдлууд багтсан байж болно.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц аргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайланд санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг.

67
Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилцсан.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль" -ийн 94-р зүйлд заасан хуулийн өнгөөд бэлэж "Хөвсгөл алтандуулга" ХК ийн удирдлагад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



"Пантер Мидланд Аудит" ХХК
Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

"ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	1/1/2022	12/31/2022
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	778,877,482.13	18,437,078.90
Дансны авлага	1,935,784,847.47	2,324,333,502.91
Татвар, НДШ-ийн авлага	3,690,909.09	7,190,822.91
Бусад авлага	2,066,200.95	0.00
Бараа материал	3,904,982,234.17	5,057,886,861.76
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	831,732,491.24	519,963,923.90
Эргэлтийн хөрөнгийн дүн	7,457,134,165.05	7,927,812,190.38
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	6,255,400,689.53	5,504,469,626.68
Биет бус хөрөнгө	34,831,317.80	16,067,294.67
Урт хугацаат хөрөнгө оруулалт	4,640,999,999.47	4,640,999,999.47
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,000,000.00	1,000,000.00
Дуусаагүй барилга	0.00	0.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,932,232,006.80	10,162,536,920.82
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	18,389,366,171.85	18,090,349,111.20
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	3,886,672,802.15	4,652,769,522.74
Татварын өр	242,095,930.50	106,199,631.76
Богино хугацаат зээл	2,294,944,323.33	3,429,099,341.71
Хүүгийн өглөг	0.00	165,939,079.48
Ногдол ашгийн өглөг	151,575,712.33	147,903,712.33
Урьдчилж орсон орлого	18,216,500.00	0.00
Бусад богино хугацаат өр төлбөр	259,965,257.04	201,810,523.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,854,270,525.44	8,703,721,811.02
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	2,228,220,193.22	1,204,361,562.29
Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,228,220,193.22	1,204,361,562.29
Өр төлбөрийн нийт дүн	9,082,490,718.66	9,908,083,373.31
Эздийн өмч		
Өмч: - төрийн	0.00	0.00
- хувийн	157,342,000.00	157,342,000.00
Халаасны хувьцаа	(531,647,877.83)	(531,647,877.83)
Нэмж төлөгдсөн капитал	3,355,642,713.72	3,355,642,713.72
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,798,703,319.76	3,515,568,123.89
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	2,526,835,297.54	1,685,360,778.11
Эздийн өмчийн дүн	9,306,875,453.19	8,182,265,737.89
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	18,389,366,171.85	18,090,349,111.20

9-29 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн

68

АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

"ХӨДСГӨЛ АЛТАНДУУПГА" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	1/1/2022	12/31/2022
Борлуулалтын орлого (цэвэр)	10,431,860,328.34	8,809,422,595.49
Борлуулалтын өртөг	10,199,393,794.16	8,108,381,599.00
Нийт ашиг (алдагдал)	232,466,534.18	701,040,996.49
Түрээсийн орлого	0.00	0.00
Хүүний орлого	0.00	0.00
Ногдол ашгийн орлого	0.00	0.00
Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
Бусад орлого	180,261,008.44	265,174,313.55
Борлуулалт маркетингийн зардал	349,635,139.17	682,585,268.42
Ерөнхий ба удирдлагын зардал	584,464,155.62	499,498,699.69
Санхүүгийн зардал	516,333,060.26	678,588,704.26
Бусад зардал	18,367,627.61	36,981,757.41
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	106,443,175.91	(7,050,550.86)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(949,629,264.13)	(838,489,670.60)
Орлогын татварын зардал	0.00	0.00
Татварын дараах ашиг (алдагдал)	(949,629,264.13)	(838,489,670.60)
Зогссон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(949,629,264.13)	(838,489,670.60)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
Бусад олз (гарз)	0.00	0.00
Орлогын нийт дүн	(949,629,264.13)	(838,489,670.60)

9-29 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

"ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	7,042,303,246.03	8,489,264,447.97
Борлуулсан, үзүүлсэн үйлчилгээний орлого	7,042,303,246.03	8,224,090,134.42
Бусад мөнгөн орлого	0.00	265,174,313.55
Мөнгөн зарлагын дүн (-)	9,704,080,530.37	8,505,583,043.97
Ажилчдад төлсөн	817,869,144.16	692,291,586.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	238,165,394.28	209,580,350.79
Бараа материал худалдан авахад төлсөн	6,462,529,375.67	5,796,169,544.43
Ашиглалтын зардалд төлсөн	45,942,596.96	210,073,138.50
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	358,469,473.00	477,954,243.00
Хүүний төлбөрт төлсөн	368,212,406.14	470,088,081.96
Татварын байгууллагад төлсөн	209,348,717.35	201,611,111.06
Бусад мөнгөн зарлага	1,203,543,422.81	447,814,988.23
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,001,777,284.34)	(16,318,596.00)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	0.00	0.00
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
Хүлээн авсан хүүний орлого	0.00	0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	123,092,895.00	645,012,835.28
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	123,092,895.00	645,012,835.28
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа	0.00	0.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(123,092,895.00)	(645,012,835.28)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	4,610,000,000.00	950,000,000.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасанаас хүлээн авсан	4,610,000,000.00	950,000,000.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргасанаас хүлээн авсан	0.00	0.00
Төрөл бүрийн хандив	0.00	0.00
Ханшийн тэгшитгэлийн ашиг	0.00	0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	1,237,836,958.55	1,049,108,971.97
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	1,237,673,122.55	1,045,941,479.77
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	0.00	0.00
Төлсөн ногдол ашиг	163,836.00	3,304,800.00
Ханшийн тэгшитгэлийн алдагдал	0.00	(137,307.76)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	3,372,163,041.45	(99,108,971.97)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	587,292,862.11	(760,440,403.28)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	191,584,620.02	778,877,482.13
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	778,877,482.13	18,437,078.85

9-29 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
"ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	I Үэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	157,342,000.00	(531,647,877.83)	3,355,642,713.72	3,798,703,319.76	2,526,835,297.54	9,306,875,453.19
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	157,342,000.00	(531,647,877.83)	3,355,642,713.72	3,798,703,319.76	2,526,835,297.54	9,306,875,453.19
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	(838,489,670.60)	(838,489,670.60)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	(286,120,044.70)	0.00	(286,120,044.70)
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	157,342,000.00	(531,647,877.83)	3,355,642,713.72	3,515,568,123.89	1,688,345,626.94	8,182,265,737.89

9-29 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн